## МОНГОЛ УЛСЫН
## ГЭГЭЭРЛИЙН САЙДЫН ТУШААЛ

1997. оны 9. сарын 20. өдөр

№ 258

Улаанбаатар хот

Тушаал хүчингүй болгох, нэмэлт өөрчлөлт оруулах тухай

Засгийн газрын 1997 оны 8 дугаар сарын 13-ны өдрийн хуралдааны 34 дүгээр тэмдэглэлийг хэрэгжүүлэх зорилгоор тушаах нь:

1. "1992 оноос өмнөх болон 1992-1997 оны Соёл, урлагийн хөгжлийн хорооны дарга, Соёлын яам, Ардын боловсролын яам /хуучнаар/, Шинжлэх ухаан, боловсролын яамны сайдын тушаалаар батлагдсан дүрэм, журам"-ыг нэгдүгээр хавсралтын ёсоор хүчингүй болгосугай.

2. 1992 оноос өмнөх болон 1992-1997 онд Шинжлэх ухаан боловсрол, Соёл, Гэгээрлийн сайдын тушаалаар батлагдсан 2 дугаар хавсралтад заагдсан эрхийн актуудыг хууль тогтоомжид нийцүүлэн нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг энэ оны 11 сард багтаан шийдвэрлүүлэхийг Стратегийн удирдлага, төлөвлөлтийн газар /Ч.Пүрэвдорж/, Төрийн захиргааны удирдлагын газар /Б.Баатарзориг/-т тус тус даалгасугай.

ХӨДӨӨ АЖ АХУЙ ҮЙЛДВЭРИЙН
САЙД БӨГӨӨД ГЭГЭЭРЛИЙН САЙДЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ Л. НЯМСАМБУУ